

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

20²⁵ оны 02 сарын 20-ны өдөр

Дугаар БА-058/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой 48 (дөчин найм) айлын хүчин чадал бүхий орон сууцны зориулалттай барилга (А блок), 86 (наян зургаа) автомашины хүчин чадал бүхий газар доорх дулаан зогсоолын зориулалттай Ү0.00 түвшнээс доош 1 давхар, 52.0м*38.0м (С блок), Ү0.00 түвшнээс доош 1 давхар, 79.0м*28.0м (F*- E*) нийт 3 блок барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023.11.30 огноо, 0001818 дугаартай.
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар К-04-А/18, 04-06/1960 мэдээллийн санд хүлээн авсан актийн дугаар, ерөнхий магадлалын 158/2019 дүгнэлт
- 2.3. Захиалагч: Могоул ибиз ХХК оноосон нэр, 5083338 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 дугаар хороо, Тэнгэр вилла хотхон, 118 тоот 99992332 холбоо барих утас.
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Их Хайрхан Констракшн ХХК оноосон нэр, 9011602015 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6051715 регистрийн дугаар, БУ18-956/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, 44-р байр 9 тоот, утас: 99117401
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч: Байхгүй.
- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Конар ХХК оноосон нэр, 9011579010 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6019463 регистрийн дугаар, 3Т19-214/17 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо, 4 дүгээр хороо, хот айл ХХК-ийн байр, 99193158 холбоо барих утас,

Улаанбаатар хот
Хан-Уул дүүрэг
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Стандарт хийт ХХК оноосон нэр, 9011676093 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6196543 регистрийн дугаар, 31/2018, 32/2018, 00462 тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Их монгол улсын гудамж, Ривер стрийт Хан хиллс хотхон-535,

Могоул ибиз ХХК оноосон нэр, 5083338 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 дугаар хороо, тэнгэр вилла хотхон, 118 тоот 99992332 холбоо барих утас

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой 48 (дөчин найм) айлын хүчин чадал бүхий орон сууцны зориулалттай барилга (А блок), 86 (наян зургаа) автомашины хүчин чадал бүхий газар доорх дулаан зогсоолын зориулалттай ᠓0.00 түвшнээс доош 1 давхар, 52.0м*38.0м (С блок), ᠓0.00 түвшнээс доош 1 давхар, 79.0м*28.0м (F*-E*) нийт 3 блок барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар

болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт .. хуудас, хуралдааны тэмдэглэл .. хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт .. хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой 48 (дөчин найм) айлын хүчин чадал бүхий орон сууцны зориулалттай барилга (А блок), 86 (наян зургаа) автомашины хүчин чадал бүхий газар доорх дулаан зогсоолын зориулалттай Ү0.00 түвшнээс доош 1 давхар, 52.0м*38.0м (С блок), Ү0.00 түвшнээс доош 1 давхар, 79.0м*28.0м (F*- E*) нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүрэг 17 дугаар хороонд “Могоул ибиз” ХХК-ийн захиалгатай 48 айлын орон сууц, газар доорх дулаан зогсоолын (А, С, F*- E*) нийт 3 блок барилга

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


Нарийн бичгийн дарга:
Могоул ибиз ХХК-ийн
Ерөнхий инженер

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



/А.Мөнгөн/

/Д.Билгүүн/



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 17 ДУГААР
ХОРООНД МОГУЛ ИБИЗ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 12 ДАВХАР,
7 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ 48 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ
ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, 86 АВТОМАШИНЫ ГАЗАР ДООРХ ДУЛААН
ЗОГСООЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ 3 БЛОК БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд баригдсан зоорьтой 12 давхар, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой 48 (дөчин найм) айлын орон сууцны зориулалттай барилга (А блок), 86 (наян зургаа) автомашины газар доорх дулаан зогсоолын зориулалттай 70.00 түвшнээс доош 1 давхар, 52.0м*38.0м (С блок), 70.00 түвшнээс доош 1 давхар, 79.0м*28.0м (F* - E*) нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын А блокийн 5 давхрын хурлын танхимд 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 09:00 цагт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

Комиссын дарга:

- | | |
|---|----------------|
| 1. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Комиссын нарийн бичгийн дарга: | Б.Батчимэг |
| 2. Могоул ибиз ХХК-ийн Ерөнхий инженер | Д.Билгүүн |
| 3. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Б.Шинэжаргал |
| 4. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5. Ухаалаг эрчим ХХК-ийн Албаны дарга | В.Алтай |
| 6. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга | Д.Сүхбат |
| 7. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Д.Болормаа |
| 8. Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | Н.Болор-Эрдэнэ |
| 9. Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын тасгийн дарга, дэд хурандаа | Б.Мягмаржав |
| 10. Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | Г.Уртнасан |
| 11. Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч | Н.Өлзийжаргал |

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Н.Өлзийжаргал
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

- | | |
|---|-----------------------------|
| 12. Ашиглалт хариуцах “Стандарт хийт” ХХК-ийн Ерөнхий инженер | Э.Эрдэнэцэцэг |
| 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Ч.Уранчимэг |
| 14. Гүйцэтгэгч Их Хайрхан Констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал | Ө.Ерөөлт |
| 15. Зураг төсөл зохиогч Конар ХХК-ийн инженер Зураг төсөл зохиогч Энсу бэст ХХК-ийн захирал | Г.Ганцолмон Х.Пүрэвсүрэн |

ИРЦИЙН БАЙДАЛ:

Мэдэгдэл хүлээн авсан – 15

Хуралд оролцож санал гаргасан - 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд баригдсан зорьтой 12 давхар, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой 48 (дөчин найм) айлын орон сууцны зориулалттай барилга (А блок), 86 (наян зургаа) автомашины газар доорх дулаан зогсоолын зориулалттай ᠓0.00 түвшнээс доош 1 давхар, 52.0м*38.0м (С блок), ᠓0.00 түвшнээс доош 1 давхар, 79.0м*28.0м (F*- E*) нийт 3 блок барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

Комиссын дарга ирц бүрдсэнийг онцолж хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулснаар барилгын үзлэг, шалгалт эхлэв.

СОНССОН НЬ:

Комиссын бүрэлдэхүүнд томилогдон ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Захиалагч “Могоул Ибиз” ХХК-ийн ерөнхий инженер Д.Билгүүн:

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Ашиглалт хариуцах “Стандарт хийт” ХХК-ийн ерөнхий инженер Э.Эрдэнэцэцэг:

- Ус, дулаан дамжуулах төвд тоног төхөөрөмжийг виркжүүлэлт хийх Ашиглалтад хүлээж авахыг саналтай.

Зураг төсөл зохиогч “Конар” ХХК-ийн Инженер Г.Ганцолмон:

- Барилга бүтээцийн угсралтын ажлыг баталгаажсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг барилгыг ашиглалтанд хүлээн авах саналтай байна. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

“Энсу Бэст” ХХК-ийн Захирал Х.Пүрэвсүрэн:

- Барилгын ажлын гүйцэтгэлийг харгалзан үзээд барилгыг байнгын ашиглалтад авахад татгалзах зүйлгүй гэж үзэж байна

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч

Б.Шинэжаргал:

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ, улаан журнал, ил далд ажлын акт, бетон бат бэхийн шинжилгээний бичиг үзүүлэх
- Лифтний магадалгаа улсын байцаагчийн өгсөн албан шаардлагын биелэлт фото зургаар үзүүлэх
- Айлуудын дутуу заслын ажил дуусгах
- Захиалагчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн баталгаажуулан ирүүлэх
- Гүйцэтгэгч байгууллагаар чанарын баталгаа БТХ – ийн дагуу гаргаж албан тоотоор ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна худаг зургийн дагуу норм стандартад нийцүүлэн угсран фото зургаар шалгуулах
 - Үзлийн өрөөнд тоног төхөөрөмжид хаягжуулалт үзлийн шал будаж янзлах
 - Дээвэр дээрх үнэр гаргагч дулаалга хийх
 - Зоорины давхарт АС – ийн шугам хоолойнууд зургийн дагуу гүйцэд угсрах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

“Ухаалаг эрчим хүч” ХХК-ийн Албаны дарга **Б.Алтай:**

- Хан хиллс хотхоны доор байрлах агуулахын ЦАХ-н хэрэглээг тооцоолох, тоолуур суурилуулах, хэрэглээг нийтийн эзэмшлийн хэрэглээнээс салган суулгах
 - Ухаалаг тоолуурын дата мэдээллийг алсын зайнаас авах, таслах залгах үйлдлийг гүйцэтгэх модулийг суурилуулан тестлэх
 - Айл өрх гражын ЕС, ХС, ГС-үүдын хаяг бичиглэлийг стандартад нийцүүлэн бүрэн дуусгах хийж бүрэн дуусгах зургаар баталгаажуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Улаанбаар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга **Д.Сүхбат:**

- Тоног төхөөрөмж сайн чанартай угсралт хийсэн байна
 - Тухайлсан санал байхгүй
- Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын тасгийн дарга, дэд хурандаа **Б.Мягмаржав:**

- Нэгдсэн зогсоолд гал унтраах автомат системийг ашиглалтын бэлэн байдлыг хангуулах
- Нэгдсэн зогсоолд галын дохиоллын систем гал түймрийн үеийн утаа зайлуулах, агаар өгөх системийг нормын дагуу угсралт хийж, автомат холболт хийх
- В1 давхарт зургийн дагуу шатны хонгилийн өмнө гонх, хаалт хийх, шатны хонгилд галд тэсвэрлэлтийн зэрэг бүхий хаалга хийх
- Шатны хонгилийн хаалганд өөрөө хаагдагч тоноглол хийх

- Галын дотуур даралтат усны цэгийн байршилын зургаас өөрчлөгдсөн /нормын дагуу байрлуулах/
- Галын тохиололын системийг цахилгаан шаттай автомат холболт хийх
- Гал түймрийн үеийн утаа зайлуулах сорох агаар өгөх системийн босоо шугам цайрдсан гөлмөн төмрийг зургийн дагуу тоосгоор тусгаарлах. Сэнсний хүчин чадал өөрчлөгдсөн байна /Зохиогч тайлбар өгөх/

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан нормчлолын сангийн төлбөрийг төлөх
 - техникийн давхарт дээвэр рүү гарах шатанд бариул хийх
 - дотор заслын ажил дутуу айлуудын гэрээг шалгуулах
 - В1 давхрын аваарын гарцны дээврийг ажлын зургийн дагуу гүйцээх
 - Батлагдсан ЕТ дагуу тохижилт хүүхдийн тоглоомын талбай хийх
- Үүрэг даалгавар биелсэн тохиолдолд ашиглалтад оруулах саналтай.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч **Н.Өлзийжаргал:**

- Ил далд ажлын актын гарын үсгийн бүрдлийг гүйцээж баталгаажуулах
 - Баримт бичгийн бүрдлийг архивд хүлээлгэн өгөх.
 - Нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлэх, хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
 - Ажлын зураг болон холбогдох эх хувийг архивд хүлээлгэн өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан **Ч.Уранчимэг:**

- Бордюур нам болгох
- Цахилгаан шатанд зарлан мэдээлэгч хийх
- Авто зогсоолын 2 налуу зам стандартын дагуу болгох
- Машины зогсоолд ХБН тэмдэглэгээ хийх

Улсын комиссын гүшүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна

Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Гадна холбооны акт бүрдүүлж өгөх
- Зоорины давхарт гадна оролтоос холбооны өрөө хүртэл кабелийн тавиур суурилуулах
- Холбооны өрөө, давхрын самбарыг хаягжуулах
- Ил далд ажлын актуудыг бүрдүүлэх
- Дутуу суурилуулсан тоноглолуудыг гүйцээх хэвийн ажиллагаанд оруулах (Домофон, разетка)
- Холбооны өрөөний шалыг гүйцээх

Үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авах саналтай.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- Нийслэлийн эрүүл мэндийн газарт ундны усны дээж агч дүгнэлт гаргуулах
- Нөөцийн савны юүлэх, хоослох усыг зайлуулах трапп хийх
- Нөөцийн саванд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэн актаар баталгаажуулах. Техник ашиглалтын паспорт хөтлөн хэвийн ажиллагааг хангах
- Усны тоолуурын заалт авах боломжтой болгох. Хит өндөр авто зогсоол дээр байрласан байна
- Өргөлтийн насос, нөөцийн савны аюулгүй ажиллагааг ханган хаалт хийх
- БУ-ны дарагдсан худгийг ил гарган үзүүлэх
- БУ – ны уклон алдсан, тунаатай байгаа тул дахин шалгаж хяналт тавиулах, УСУГ, ашиглалт хариуцах байгууллагаар
- Техникийн нөхцөлийн шаардлагын дагуу гадна ЦУ – ны худагт голын гидрант суурилуулах
- УСУГ-тай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ байгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Гүйцэтгэгч Их Хайрхан Констракшн ХХК-ийн Гүйцэтгэх захирал **О.Ерөөлт:**

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан бичгээр ирүүлэх
- Тоглоомын талбайд тоноглол суурилуулах, тохижуулах ажил дуусгах хугацааг баталгаа албан бичиг ирүүлэх
- “Энсу бэст” ХХК-ийг зураг зохиогчоор тусгасан БАЭҮЗ-ийн гэрчилгээний хуулбар ирүүлэх
- Зохиогч, захиалагч нар дүгнэлтээ шинэчлэн ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

АЛТЫН

г ашиглалт
исс

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд баригдсан зорьтой 12 давхар, 7 (долоо) автомашины дулаан зогсоолтой 48 (дөчин найм) айлын орон сууцны зориулалттай барилга (А блок), 86 (наян зургаа) автомашины газар доорх дулаан зогсоолын зориулалттай ᠓0.00 түвшнээс доош 1 давхар, 52.0м*38.0м (С блок), ᠓0.00 түвшнээс доош 1 давхар, 79.0м*28.0м (F*- E*) нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах, комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



/Б.Батчимэг/

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:
"Могоул ибиз" ХХК
Ерөнхий инженер

/Д.Билгүүн/

Энд